ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.07 № 1233

танай ________-ны №________-т

ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД
НАМД

**Хандивын тайлангийн дүгнэлт**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Дэлхийн Монголчууд намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Дэлхийн Монголчууд нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Нийслэл дэх төрийн аудитын газар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Дэлхийн Монголчууд намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон

улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

**Дүгнэлт**

Дэлхийн Монголчууд нам нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна. Дэлхийн монголчууд намаас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хувийг: Нийслэлийн сонгуулийн хороонд

Хавсралт: 1... хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж дүгнэлт гаргах зааврын хавсралт

**МАЯГТ-1**

## Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэлд "ИРГЭН" -ээс өгсөн хандивын тайлангийн маягт

## Дэлхийн Монголчууд Нам

| д/д | Иргэний овог нэр | Хандив өгсөн иргэний мэдээлэл | | | | Хандив өгсөн огноо | Хандивын мөнгөн дүн | Хандив хүлээн авсан | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Регистрийн дугаар | Нас | Оршин суугаа хаяг | Утасны дугаар | | | Банкны нэр | Дансны дугаар | |
| Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон | | | | | | | | | | |
| 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд | | | | | | | | | | |
| 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - |

Тамга, тэмдэг

Хянасан: НАМЫН ЗЭЭД (албан тушаал) П.ХОСБАЯР (овог нэр) /................................./ (гарын үсэг)

2020.06.19
огноо

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж
дүгнэлт гаргах зааврын хавсралт

**МАЯГТ-2**

**Нийслэл дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД" - ээсэгсөн хандивын тайлангийн маягт**

**Дэлхийн Монголчууд Нам**

| д/д | Хуулийн этгээдийн нэр | Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл | | | | | Хандив хүлээн авсан | | | Мөнгөн дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Регистрийн дугаар | Хаяг, утасны дугаар | Үүсгэн байгуулагдсан огноо | Үйл ажиллагааны чиглэл | Хуулийн этгээдийн хэлбэр | Огноо | Банкны нэр | Дансны дугаар | | |
| Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ны эдрөөр тасалбар болгосон | | | | | | | | | | | |
| 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд | | | | | | | | | | | |
| 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

Тамга, тэмдэг

Хянасан: НАМЫН ЕНЕД П.ХОСБАЯР /............................../
албан тушаал овог нэр гарын үсэг

2020-06-19
огноо